



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/259

Эрдэнэт

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.б, 29.2, Тариалангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны ээлжит IV хуралдааны II, 2017 оны ээлжит V хуралдааны 5/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн хэмжээнд хаврын тариалалтыг технологийн хугацаанд чанартай гүйцэтгэх ажлыг шуурхай зохион байгуулах, тариалалтын чанарыг соёололтоор нь хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг I, шатахууны зардлыг II хавсралтаар тус тус баталсугай.

2. Хаврын тариалалтыг технологийн хугацаанд чанартай гүйцэтгэх ажлыг шуурхай зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ажлын явцыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, тариалалтын чанарыг соёололтоор хүлээн авч дүн мэдээг холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /н.Бат-Өлзий/-т, мал бүхий иргэдийг нүүлгэн шилжүүлэх, малыг байнгын хариулга маллагаа, хараа хяналттай байлгаж таримал ургамлыг малын хөлөөс хамгаалах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийн бүрэлдэхүүний шатахууны зардалд шаардагдах 459000 /дөрвөн зуун тавин есөн мянган/ төгрөгийг /Газар тариалангийн цаг үеийн ажлаар газар тариалангийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах/ зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /н.Баяржаргал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
05 дугаар сарын 08...-ны өдрийн
1/259 дугаар захирамжийн II хавсралт

АЖЛЫН ХЭСЭГТ ШААРДАГДАХ ШАТАХУУНЫ ЗАРДАЛ

№	Явах газрын чиглэл, нэр	Нэг удаа явах зай /км/	Явалтын тоо	Бүгд /км/	100 км-т зарцуулах шатахуун /л/	Нийт шатахуун /л/	Шатахууны нэгжийн үнэ /төг/	Нийт үнэ /төг/
Хаврын тариалалтын бэлтгэл хангуулах, тариалалтын чанарыг соёололтоор хүлээн авах								
1	Улаантолгой Хангал өртөө	120	5	600	18	108	1500	162000
2	Цагаан тавилан гурван эвэртэй	180	2	360	18	64.8	1500	97200
3	Баруунбүрэн Хөшөөт	130	2	260	18	46.8	1500	70200
4	Хутаг-Өндөр Хантай баян ХХК	480	1	480	18	86.4	1500	129600
Дүн								459000